

МЭДЭЭЛЛИЙН НИЙГЭМ, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛД

З.Серик*

* МУИС, НШУС-ийн Социологи, нийгмийн ажилтны тэнхимийн багш, магистр

Түлхүүр үг: мэдээллийн нийгэм, мэдээллийн зуун, мэдлэгийн нийгэм, мэдээлэлжсэн нийгэм, мэдээллийн бөмбөг, орчин үеийн нийгэм, орчин үеийн дараах нийгэм, глобализм

Өнгөрсөн зууны далаад оноос (1975 оноос) хойш нийгмийн шинжлэх ухааны эргэлтэнд орсон шинэ нэр томъёо бол information society буюу мэдээллийн нийгэм юм. Өнөөдөр бараг хүн болгон энэхүү нэр томъёоны учир утгыг тунгаан бодоогүй байж, “XXI зуун бол мэдээллийн зуун”, “Бид мэдээллийн эринд амьдарч байна” хэмээн ярьдаг болжээ. Гэтэл энэхүү мэдээллийн нийгэм гэж юу вэ? Хэзээ, яаж бий болсон бэ? Ямар ач холбогдолтой юм бэ? зэрэг цөөнгүй асуултад бүрэн хариулт өгсөн хүн бараг алга байна. Тэгвэл мэдээллийн нийгмийн талаарх олон асуулт өнөөдөр хүртэл нэг мөр болоогүй, бас судлаачдын дунд янз бүрийн маргаан мэтгэлцээн төрүүлсээр байна. Мэдээллийн нийгмийн чухал үзүүлэлтийн нэг болсон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дээрх асуултуудын талаар цөөн тооны материал нийтлэгддэг боловч мэдээллийн нийгмийн үндсэн ойлголтуудаас

нэлээд хол байгаа нь ажиглагддаг. Бид энэ өгүүлэлд дээрх асуултуудад ямар нэг хэмжээгээр хариулт өгөхийг оролдсон болно.

“Мэдээлэл” буюу “information” гэх үгийн үндсийг хөөж үзвэл латин хэлний informare буюу хэлбэржүүлэх гэсэн утгатай үг юм (in – латин хэл буюу аливаа латин хэлнээс гаралтай бүх хэлэнд байдаг нэрээс үйл үг үүсгэх утгвар, formare – гэдэг нь “хэлбэр” буюу “хэлбэрт орох” гэсэн утгатай). Харин орчин үеийн зарим хэлэнд, тухайлбал англи хэлэнд, “хэлбэржүүлэх” гэсэн утгаар биш “мэдээлэх” гэсэн хийсвэр утгаар хэрэглэгддэг. Гэхдээ “хэлбэрт оруулах” буюу шилжсэн утгаараа “үүсгэх” болон “мэдээлэх” гэсэн хоёр үгний хооронд ямар ч ялгаа байхгүй. Дараах үгэн дээр жишээ авбал ойлгомжтой болно. Тухайлбал, англи хэлэнд inform гэх үг ямар нэгэн юмыг мэдээлэх гэсэн утгыг агуулдаг. Жишээ нь, Have you informed them about our recent visit? буюу “Чи тэдэнд бидний хамгийн сүүлчийн айлчлалын тухай мэдэгдсэн үү?” Тэгвэл дараах өгүүлбэрийг анхаарна уу: Light is informing my senses! – Гэрэл миний мэдрэхүйд “мэдээлж байна”!. Энэхүү

сүүлчийн өгүүлбэрийн монгол орчуулга нь алдаатай мэт байж болох юм. Гэвч тийм биш. Хэрэв бид гадаад буюу дотоод ертөнцтэй зөвхөн sense буюу мэдрэхүй-н тусламжтайгаар харьцдаг гэвэл гаднаас ирж буй ямар нэгэн цочрол, тухайлбал, гэрэл, бидний мэдрэхүйд тусан мэдрэмж (feeling)-ийг үүсгэж байгаа нь тодорхой юм.

Энэхүү "мэдээлэл" гэх нэр томьёо нь харилцаа судлалд (communication studies) 1950-иад оны үед хэрэглэгдэж байгаад эхлээд инженерчлэл, математикийн шинжлэх ухаанд, дараа нь нийгмийн шинжлэх ухаанд орж ирсэн түүхтэй юм. Харин нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэгдэж байгаа мэдээлэл гэсэн тодотголтой үгс нь (түүний дотор мэдээллийн нийгэм) нэлээд нарийн түвэгтэй замыг туулж байж бидний үгийн санд орж ирсэн. Учир нь мэдээллийн нийгэм гэсэн нэр томьёо ихэнх хүмүүст цоо шинэ нийгмийн тухай төсөөллийг төрүүлдэг ба хэрэв үгүй гэвэл яагаад? гэсэн асуулт гарч ирдэг. Энэ нь нийгмийн шинжлэх ухаанд яригддаг хөгжлийн тухай хоёр том үзэл баримтлалтай холбоотой юм.

Бид нар өөрсдийгөө "орчин үеийн" гэж нэрлэх тун дуртай. Гэтэл энэ юу гэсэн үг вэ? Үнэхээр бодитой зүйл үү? Эсвэл энгийн ярианд байдаг "моод" болсон үг үү? Нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд "орчин үе" гэдэг үг бодитой бөгөөд өөрийн гэсэн эхлэлтэй гэж үздэг. Эрдэмтдийн ихэнх хэсэг энэ нь капиталист нийгмийн хөгжил буюу түүний аж үйлдвэржилтийн үйл явцтай шууд холбоотой гэж үздэг. Капиталист нийгмийн гол зорилго нь тасралтгүй үйлдвэрлэл явуулж ашиг олоход оршдог бөгөөд чухам энэ үйл явц бидний амьдралыг өөрчилж, биднийг "уламжлалт" (traditional) нийгмээс

"орчин үеийн" (modern) нийгэмд аваачсан гэж ойлгож болно. Тасралтгүй ашиг олоход чиглэсэн энэ нийгэм ашиг олж болох бүх аргыг сүвэгчилж, нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээг ямагт ихэсгэхийг оролдон үйлдвэрлэлийн технологийг ойр ойрхон шинэчилж байдаг онцлогтой. Тэгвэл бид капиталист нийгмийг юуны өмнө шинжлэх ухаан, технологийн нийгэм гэж нэрлэх учиртай. Үүнээс үзэхэд орчин үеийн гэгдэх нийгмийн хамгийн гол шинжийн нэг бол шинжлэх ухаан, технологийн дэвшил байдаг нь тодорхой юм. Дараагийн нэг онцлог шинж нь хүний бараг бүх харилцаа таваржиж эхэлдэг бөгөөд "Чамд төлбөрийн чадвар байвал үр өгөөжийг нь хүрт, байхгүй бол чадвартай болсон цагт ир" гэсэн зарчмыг баримталдаг. Ийм нийгэм улам бүр рациональ болж эхлэх нь тодорхой. Энэ бол зорилгодоо хүрэх аргаа зөв тооцоолж чаддаг, бас өөртөө хэрэгтэй зүйлээ авч чаддаг гэсэн үг юм. Ийм сэтгэлгээ төлөвшиж чадаагүй хүн хэзээ ч капиталист нийгмийн гишүүн болж чадахгүй. Капиталист нийгэм маш олон шинжтэй боловч бидний дээр дурдсан шинжүүд бол шууд үнэмлэхүй утгаараа байнга мэдрэгдэж байдаг хамгийн гол шинжүүд юм. Бид ихэнх тохиолдод капиталист нийгмийг орчин үеийн нийгэм мөн гэж ойлгодог. Тэгвэл энэхүү "орчин үеийн" гэдгийг яаж ойлгож болох вэ? Судлаачдын үзсэнээр "орчин үед" амьдарч байгаа хүмүүс өөрийгөө урьд өмнө байгаагүй хөгжлийн оргилд амьдарч байна, бас өмнөх үетэй харилцаа холбоогоо бүрэн тасалсан гэсэн хоёр зүйлийг шууд мэдэрч байдаг байна.

Ихэнх судлаачид орчин үеийн нийгмийн үндсийг аж үйлдвэрийн хувьсгал тавьсан гэж үздэг. Тэгвэл мэдээллийн нийгэм энэ үеэс яригдах

сэдэв мөн үү? "Тийм" гэж хариулах хүн цөөнгүй байж болно. Үнэн хэрэг дээрээ тийм биш юм. Учир нь мэдээллийн "хувьсгал" зарим судлаачдын үзсэнээр, орчин үед эхлээгүй юм. Тэгвэл хэзээ эхэлсэн болох вэ? Энэ бол бидний дээр дурдсан нарийн түвэгтэй замын нэг юм. Учир нь мэдээллийн нийгмийн тухай ойлголт "орчин үеийн дараах" (postmodern) нийгэмд үүссэн гэдэг. Тэгвэл орчин үеийн дараах нийгэм гэж ямар нийгэм байдаг вэ? Энэ бол орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны философи хариулж чадаагүй байгаа асуулт юм. Учир нь энэхүү хоёр шинжлэх ухааны хөдөлгөөнөөс (modernism and postmodernism) болж, эрдэмтэд хоёр хэсэгт хуваагдаж, одоо хүртэл нэг мөр тодорхойлолт өгч чадаагүй юм.

Эрдэмтдийн нэг хэсэг нь "орчин үеийн дараах" (postmodern) гэсэн үзэл баримтлалыг дэмжиж байхад, нөгөө хэсэг нь үүнийг үгүйсгэж "орчин үеийн" (modern) гэгдэх нэр томъёонд үнэнч үлдэн, янз бүрийн хувилбарыг нь ашигласан хэвээр байна. Хэрэв бид орчин үеийн дараах нийгэм байна гэдэгт итгэвэл юуны түрүүнд "орчин үеийн" гэж ямар нийгэм байгааг маш сайн ойлгох хэрэгтэй юм. Энэ бол тун сонирхолтой, бас анхаарал татахуйц сэдэв мөн боловч манай улсад яригдах байтугай ойлголт ч үгүй явж байгаа нь харамсалтай.

Орчин үеийн дараах нийгмийг тодорхойлох нь бидний дээр дурдсан

олон хүчин зүйлээс шалтгаалан амаргүй гэдэг нь ойлгомжтой. Гэвч энэ ойлголт бол мэдээллийн нийгэмтэй шууд холбоотой учраас ямар нэг хэмжээгээр хөндөх шаардлагатай юм. Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд орчин үеийн болон орчин үеийн дараах гэсэн үзэл баримтлалын хөдөлгөөнд үндэслэгч гэж байхгүй бөгөөд харин шинжлэх ухаан болон урлаг, соёлын салбарт гарсан хөдөлгөөнүүдийн үр дүн мөн. Үүний нэг тод жишээ бол 1968

онд Европт (тухайлбал, Францад) өрнөсөн үйл явдал юм. Орчин үеийн дараах нийгмийн талаар эрдэмтэд янз бүрийн таамаглал дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Америкийн социологич Даниэл Белл (1976) орчин үеийн дараах нийгмийг аж үйлдвэржилтийн да-

раах нийгэм (postindustrial society) гэж тодорхойлжээ. Ингэж тодорхойлсон эрдэмтэд цөөнгүй байдаг бөгөөд аж үйлдвэржсэний дараах гэдэг нь орчин үеийн дараах нийгэм нь хүнд машин механизм бүхий үйлдвэрлэл явуулах нь багасч, ихэнх ашиг олох салбар нь үйлчилгээний салбар болно гэж үзсэнтэй холбоотой. Үүнийг хүлээн зөвшөөрөх үндэслэлтэй юм. Учир нь орчин үед "уламжлалт" ажилчин ангиас илүү менежмент, маркетинг, IT мэтийн уян хатан, авьяас, шинэ санаа шаардсан мэргэжил давамгайлах болсон. Үүнээс үүдэн зарим судлаач ажилчин анги байхгүй болж байгаа нь орчин үеийн дараах нийгмийн нэг шинж

«

Эрдэмтдийн нэг хэсэг нь "орчин үеийн дараах" (postmodern) гэсэн үзэл баримтлалыг дэмжиж байхад, нөгөө хэсэг нь үүнийг үгүйсгэж "орчин үеийн" (modern) гэгдэх нэр томъёонд үнэнч үлдэн, янз бүрийн хувилбарыг нь ашигласан хэвээр байна. Хэрэв бид орчин үеийн дараах нийгэм байна гэдэгт итгэвэл юуны түрүүнд "орчин үеийн" гэж ямар нийгэм байгааг маш сайн ойлгох хэрэгтэй юм.

»

мөн гэсэн дүгнэлтэд хүрдэг. Беллийн үзсэнээр аж үйлдвэржсэний дараах нийгэм нь 1) улс үндэстнүүдийн хооронд эрчимтэй аялал жуулчлал хөгжнө, 2) их хэмжээний нэмүү бүтээгдэхүүн бий болно, 3) үйлчилгээний салбар улам ихсэн ихэнх ажилчдыг ажиллуулах болно, 4) дундаж хүнд дунджаар өмнөх үеэсээ илүү их нэр төрлийн болон хэмжээний бараа бүтээгдэхүүн ноогдох болно, 5) "мэдээллийн тэсрэлт", 6) "дэлхийн хэмжээний тосгон" бий болох буюу дэлхийг хамарсан шууд харилцаа сүлжээ бий болно гэсэн шалгууруудаар тодорхойлогдох болно.

Орчин үеийн дараах нийгэм гэдгийг маш энгийнээр орчин үеийн биш нийгэм гэж ойлгож болох юм. Гэтэл яг энэ асуудлаас болж орчин үеийн болон орчин үеийн дараах нийгмийг дэмжигч эрдэмтдийн дунд ширүүн маргаан өрнөсөөр байна. Орчин үеийн биш нийгэм гэвэл энэ нь цоо шинэ, өөрчлөлт бүхий нийгэм мөн гэсэн дүгнэлтэд хүргэдэг. Гэтэл Английн Франк Уэбстер (2006) мэт зарим эрдэмтэн энэ нь түүхийн залгамж чанарыг (continuity) алдагдуулаад байгаа хэрэг биш үү? Чухам яагаад орчин үеийн дараах нийгэм байх ёстой юм бэ? гэж асуух шаардлагатай гэж үздэг. Учир нь эдгээр эрдэмтэд орчин үеийн дараах нийгэм нь мөн чанар, утга учрын хувьд мэдээллийн нийгэмтэй ижил төстэй гэж үздэг байна. Гэхдээ орчин үеийн дараах буюу мэдээллийн нийгэм байгаа гэдгийг ямар үндэслэлээр нотлох вэ? Хэрэв энэ нь цоо шинэ нийгэм юм бол "шинэ" гэдгийг юу гэж ойлгох вэ? гэдэг асуултууд ар араасаа урган гарч болно. Уэбстер энэхүү асуултуудын хүрээнд мэдээллийн нийгмийн онолыг баримтлагчид бүдэрдэг гэж үзээд, "мэдээллийн тэсрэлт" мэтийн үзэгдэл,

эсвэл үйлчилгээний салбар өргөжиж, IT зэрэг мэргэжил ихэссэнээр амьдрал өөрчлөгдөнө гэдэг нь эргэлзээтэй үзэл гэж дүгнэсэн байдаг. Учир нь амьдрал өөрчлөгдөнө гэдэг бол тоо хэмжээний биш, чанарын өөрчлөлт гэж үзсэн байна. Тэрбээр өөрийнхөө дэвшүүлсэн үндэслэлд тулгуурлан мэдээллийн нийгмийн таван гол шалгуурыг тодорхойлсон байдаг. Одоо энэ талаар товч өгүүлье.

Технологи. Мэдээллийн нийгмийг анх тодорхойлогчдын дотор технологийн дэвшлийн ач холбогдлыг гол шалгуур, үндэслэл болгогчид цөөнгүй байсан бөгөөд мэдээлэл харилцааны технологийн хөгжил нь мэдээллийн нийгмийн үндсийг тавьж байна гэж үзсэн юм. Ийм үзэл баримтлал анх 1970-аад оны сүүлд, дараа нь 1990-ээд оны эхээр хоёр удаа давтагдсан байдаг. 1970-аад оны сүүлчээр яригдах болсон шалтгаан нь тухайн үед микрочип дээр тулгуурласан технологиуд гарч ирсэнтэй холбоотой юм. Тэр үеийн томоохон төлөөлөгчдийн нэг болох Америкийн ирээдүй судлаач Элвин Тоффлер (1980) хүн төрөлхтний нийгмийг: уламжлалт нийгмийг тодорхойлсон газар тариалангийн хувьсгал, орчин үеийн нийгмийг тодорхойлсон аж үйлдвэрийн хувьсгал, аж үйлдвэрийн дараах нийгмийг тодорхойлох ёстой ирж буй мэдээллийн хувьсгал гэсэн гурван янзын давалгаа тодорхойлох болно гэж дүгнэжээ.

Харин 1990-ээд оны үед дээрх үзэл баримтлал давтагдах болсон нь Интернетэд суурилсан харилцаа холбооны технологи өндөр хөгжсөнтэй холбоотой юм. Нөгөө талаар хүмүүс иймэрхүү Интернетийн холбоо, факс, пэйжер мэтийн технологиуд нь нийгмийн харилцааг хурдасгаж, ардчиллыг хөхиүлэн дэмжих

амжилт авчрах болно гэж үздэгтэй холбоотой байжээ.

Энэхүү технологийн онолыг баримтлагчид мэдээллийн нийгмийг мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжил авчирч байна гэж үздэг байв. Тэдний бодлоор ийм мэдээлэл харилцааны технологиор нөхцөлдсөн асар уудам мэдээллийн "зам" бий болох бөгөөд түүнд холбогдсон хэн боловч мэдээллийн нийгэмд амархан орох юм. Технологийн ийм үзлийг баримтлагчид мэдээллийн нийгмийн онолын эхэн үеийн төлөөлөгчид байсан бөгөөд бүр 1960-1970-аад оны үед ч мэдээллийн нийгмийг технологийн үзүүлэлтээр тодорхойлох гэж оролдож байв. Энэ үеийн гол төлөөлөгчдийн нэг бол Японы мэдээллийн нийгмийн онолын эцэг гэгдэх Ёнежи Масуда (1981) юм.

Харин Уэбстер энэхүү технологийн хөгжил үнэхээр шинэлэг боловч түүний олон асуудал тун бүрхэг юм гэж тодорхойлжээ. Чухам ямар шалгуурыг бариад бид мэдээллийн нийгэмд орж байна? Мэдээллийн нийгэм гэдэг чинь хүн болгон компьютертэй болно гэсэн үг үү? Эсвэл янз бүрээр гарч байгаа iPhone, Blackberry-г үзүүлэлт болж авах уу? Эсвэл энэ бүхэн биш, харин ажлын зохион байгуулалтууд компьютержээд байгааг хэлээд байна уу? гэсэн асуултуудыг тавьсан байдаг.

Хоёр дахь эргэлзээ нь яагаад шинэ технологи гэнэт нийгмийн гаднаас орж ирж, түүнийг бүхэлд нь өөрчлөөд байна вэ? гэсэн асуултын хариулт юм. Яагаад эдийн засаг, улс төр, соёл зэрэг нийгмийн өөрчлөлтийн бусад хэсгүүдийг орхигдуулаад байна? Энэхүү технологийн детерминизмын онол нь технологийн нийгмийн гарлыг огт авч үзээгүйд асуудлын гол утга учир нь оршино гэж Уэбстер үзсэн байна. Тухайлбал,

аливаа шинжлэх ухааны технологийн дэвшлийг хамгийн түрүүнд цэргийн салбарт хэрэглэдэг нь нууц биш юм. Тэгвэл бидний хэрэглээд байгаа энэ технологиуд бүгд цаанаа улс төрийн зорилготой байвал яах вэ? гэх зэрэг асуудлыг энэхүү технологийн детерминизмын онол орхигдуулан хэт хялбаршуулж үзсэн байдаг.

Эдийн засаг. Мэдээллийн нийгмийн эдийн засгийн онол нь өмнөхөө бодвол сонирхолтой боловч учир дутагдлттай зүйл цөөнгүй байна. Энэ онолын авч үздэг гол зүйл нь эдийн засгийн нийт орлогын хэдэн хувийг мэдээллээс олж авч байгаа вэ? гэдэг асуулт байдаг. Учир нь энэ онолыг баримтлагчид орчин үед аливаа эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой хувь нь ямагт мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа байдаг гэж үздэг. Тухайлбал, Израилийн бизнесмен Марк Порат (1977) эдийн засгийн анхдагч мэдээллийн болон хоёрдогч мэдээллийн сектор байна гэж үзэн анхдагч мэдээллийн секторт шууд зах зээл дээр борлогдон орлого авчирч чадах мэдээлэл-бараа, хоёрдогч секторт шууд үнэлэгдэхэд түвэгтэй боловч аливаа компани, төрийн байгууллагад байдаг шинжилгээ, судалгааны хэлтсүүд багтана гэж үзсэн байдаг. Тэрээр дээр дурдсан хоёр секторыг нийлүүлэн Америкийн эдийн засгийг жишээ болгон авч, энэ орны ҮНБ-ий бараг тал хувь нь мэдээллийн үйл ажиллагаанаас орж ирдэг гэдгийг онцлон тэмдэглэжээ.

АНУ мэдээлэл дээр тулгуурласан эдийн засагтай улс бөгөөд гол эдийн засгийн орлого нь мэдээлэл, үйлчилгээний бүтээгдэхүүн болон хоёрдогч сектороос орж ирж буй орлого гэдгийг тэмдэглээд АНУ-ын нийгэм бол мэдээллийн нийгэм мөн гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Уэбстер Поратын судалгаа нь үнэхээр хөдөлмөр шаардсан ажил боловч хэтэрхий субъектив зүйлүүд орсон гэж үзжээ. Тэрбээр бүх эдийн засгийг мэдээллийн ба мэдээллийн бус сектор гэж хуваах нь учир дутагдалтай гэдгийг тэмдэглэсэн байдаг. Homo Sapiens (Сэтгэдэг хүн) ба Homo Faber (Хийдэг хүн) хоёрыг хооронд нь салгах нь хэр үндэслэлтэй вэ? Химийн үйлдвэрийн шинэ бараа бүтээгдэхүүн, түүнд хэрэгтэй шинэ мэдлэг бүтээх гэж оролдож байгаа судалгааны хэлтсийн үйл ажиллагааг статистикийн зорилгоор үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас нь тусгаарлах нь хэр тохиромжтой вэ? Түүнчлэн аливаа статистик мэдээллийг хэтэрхий стандартчилах төлөвтэй байдаг бөгөөд янз бүрийн эдийн засгийн үйл ажиллагааг онцлог шинжээс нь үл хамааран бүхэлд нэг дор цуглуулах нь түгээмэл юм. Уэбстер ийм байдлаар цугларсан мэдээллийг харж байгаад телевизийн реклам эдийн засгийн хувьд илүү ашигтай гэж үзэж болох боловч мэдээллийн хувьд чанарын ялгаа гарахаа байна гэж үзжээ. Тухайлбал, хэдэн сая хувиар борлогдож байгаа The Sun сониныг илүү бага мэдээлэлтэй боловч эдийн засгийн хувьд хамаагүй үнэ цэнтэй болох Financial Times сонинтой харьцуулж болохгүй юм.

Мэргэжил. Мэргэжлийн хэв маягийн өөрчлөлт бол социологичдын дунд нэлээд өргөн тархсан сэдвүүдийн нэг юм. Мэдээллийн нийгмийн мэргэжлийн хэв маягтай холбоотой онолоор бол орчин үед биеийн хүч хөдөлмөр шаардсан ажил үгүй болж, ихэнх мэргэжил үйлчилгээний салбар руу шилжсэнээр мэдээллийн нийгмийн үндэс тавигдаж байна гэж үздэг. Учир нь эдгээр үйлчилгээний салбарт хамаарагдах мэргэжлүүд ямагт мэдээл-

лийн ажлууд (information work) юм. Интернет, гар утас, төрөл бүрийн үйлчилгээний компаниуд нь энэхүү мэргэжлийн онолын жишээнүүд болдог. Үнэхээр одоогийн Баруун Европ, Япон, Хойд Америкийн нийт ажиллах хүчний 70 гаруй хувь нь үйлчилгээ, цагаан захтнуудын ажилладаг салбарт хамрагдаж байна. Мэргэжлийн онолын томоохон төлөөлөгчийн нэг бол бидний дээр дурдсан социологич Белл мөн. Мэргэжлийн онолыг маш энгийнээр ойлговол түүний учир утга нь "биеийн хүчний бус хөдөлмөрийн түүхий эд нь мэдээлэл бөгөөд ийм мэдээллийн мэргэжлүүд эрс нэмэгдсэн нь мэдээллийн нийгмийг авчирч байна" гэдэгт оршино.

Английн Ерөнхий сайд асан Тони Блейрийн зөвлөх байсан Чарльз Лийдбийтер (2000) өөрийн Living on Thin Air хэмээх номдоо "гар хөдөлвөл ам тосдоно" гэсэн хэллэг аль хэдийнэ хуучирсаныг дурдаад, орчин үеийн эдийн засагт хэн авхаалж самбаатай, сэргэлэн, бүтээлч, өөрт хэрэгтэй сүлжээг ашиглаж чадна, тэр өнөөгийн "жингүй" эдийн засагт амжилт олно гэж тэмдэглэжээ. Өнөөгийн эдийн засаг үнэхээр сэргэлэн, шинэ санаа гаргаж, түүнийгээ хэрэгжүүлж чаддаг тийм хүмүүсийг сонирхох болсон нь үнэн юм. Үүний тод жишээ бол орчин үед дизайнер, имижмэйкер, бизнес болон улс төрийн салбарт мэргэжлийн тохиролцоо хийгчид (deal-maker), хөгжимчид, биотехнологичид, генетик инженер гэх зэрэг мэргэжил томоохон амжилт олж байгаа явдал юм.

Гэхдээ судлаач Уэбстер үйлчилгээний буюу мэдээллийн салбарт мэдээллийн мэргэжлүүд ихсэж байгаа нь үнэхээр шинэ нийгмийг авчирч чадаж байна уу? гэж асуусан нь анхаарал

татах асуудал мөн. Тэрбээр эдийн засгийн салбарт байгаа мэдээллийн мэргэжлүүдийг тоочин "мэдээллийн нийгэм ирсэн байна" гэж хэлэх нь учир дутагдалтай гэж үзсэн байна. Энэ нь тоон үзүүлэлт аливаа нийгмийг чанарын өөрчлөлтөд оруулна гэдэгт эргэлзсэнтэй холбоотой юм. Мөн аливаа салбарт байгаа мэргэжлүүдийг мэдээллийн ба мэдээллийн бус гэж хуваах нь өөрөө хэтэрхий субъектив ойлголт гэж үзжээ. Үүний учир нь мэргэжлийн онолыг баримтлагчид мэдээллийн ба мэдээллийн бус мэргэжлийн чанарын ялгааг гаргаж чадахгүй байна гэж үзсэнд байгаа юм. Тухайлбал, төмөр замын зохицуулагч тухайн төмөр замуудын бүтэц, цагийн хуваарь, галт тэрэгний тоо, дохиоллын сүлжээ, тэдний зохион байгуулалт зэргийг нэгбүрчлэн мэдэж байх ёстой бол орчин үед компьютержсэн системийн тусламжтайгаар ганц товчлуур даран энэ бүгдийг зохицуулж байна.

Харин энэ мэргэжил өнгөрсөн "аж үйлдвэрийн" зууны биеийн хүчний чухал ажил байсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Өөр нэг сонирхолтой жишээг дурдвал, хэн нэгэн хувилагч машины инженерүүдийг "мэдээллийн ажилтнууд" гэж хэлж болох юм. Тэд хувиалагч машиныг засах гэж ирэн түүнийг хөдөлгөж, өргөж, хувцсаа заваартуулан, тав тухгүй нөхцөлд ажиллаж болно. Энд мэдээллийн болон мэдээллийн бус ажлын зааг ялгаа нь хаана байгааг хэлэхэд хэцүү юм. Тиймээс Уэбстер энэ жишээ бол мэргэжлийн статистик үзүүлэлтэн дээр тулгуурлан мэдээллийн нийгмийг тодорхойлоод байгаа эдгээр судлаачид илүү тодорхой, ойлгомжтой байх ёстой гэсэн үг юм гэж үзжээ.

Орон зай. Энэ бол сүүлийн үеийн нийгмийн шинжлэх ухаанд нэлээд

өргөн дэлгэрч байгаа сонирхолтой сэдвүүдийн нэг юм. Орон зайн онолоор мэдээллийн нийгмийг тодорхойлогчид "мэдээллийн нийгэм" гэснээс илүү "сүлжээний нийгэм" (network society) гэсэн нэр томъёог илүү түгээмэл хэрэглэдэг (тухайлбал, Мануель Кастельс, 1996). Энэ онолыг баримтлагчдын онцолж үздэг зүйл бол сүлжээн дээр тулгуурласан нийгмийн шинэ зохион байгуулалтын үзэгдлүүд юм. Тухайлбал, өнөө үед бид агшин зуур дэлхийн нөгөө өнцөгт байгаа хүнтэй Интернетээр түвэггүй харьцаж, хэрэгтэй гэсэн зүйлээ дэлхийн нэг өнцгөөс нөгөө өнцөг рүү шилжүүлэн авч байна.

Ганц Интернет бус мөнгөний ATM, гар утас, зөөврийн компьютер зэрэг нь бидэнд асар их цаг хугацаа, орон зайг товчлох боломж олгож байна. Өнөөдөр ийнхүү сүлжээний тусламжтайгаар бид ямар ч улсын хилийг даван өөр улс руу чөлөөтэй нэвтэрч байна. Энэхүү сүлжээний тусламжтайгаар орон зай, цаг хугацааг товчлох үзэгдэл нь Тоффлер (1970) зэрэг судлаачдын хувьд дэлхийг улам бүр "жижиг" болгож даяар сүлжээ буюу World Wide Web гэсэн үг жинхэнэ утгаар биелж буй хэрэг юм. Ийм сүлжээний зохион байгуулалт нь бидний цаг хугацаа-орон зайн харилцааг асар их хялбарчлан ямар ч хүнд дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах боломж олгож байгаа. Тиймээс зарим судлаач ийм сүлжээг даяарчлал буюу глобализмд хүрэх бодит алхам гэж үздэг нь үнэний ортой юм.

Францын социологич Пол Вирилио (2005) энэхүү сүлжээ бүхий орон зай-цаг хугацааны хумигдалт нь глобализмыг хэрэгжүүлж буй үйл явц гэж үзээд, орчин үеийн "уламжлалт" ойлголт болох өдөр-шөнийн хэмнэл аль хэдийн алдагдсан гэж тэмдэглэжээ. Үүний

Бодит жишээ нь телевиз 24 цагийн турш дэлхий даяар нэвтрүүлгээ цацаж, хувь хүн webcam мэтийн хямдхан техникийг ашиглан орон зай, цаг хугацааг товчлон дэлхийн өнцөг буланд болж буй зүйлийг хүссэн цагтаа чөлөөтэй үзэж харах боломжтой болсон явдал юм. Вирилио: "Орчин үеийн хүний хувьд бодит байдал "дэлгэцний" бодит байдал болон хувирч, энэхүү жижигхэн "ертөнцийг харах цонхоороо" хүн эртний Грекийн үлгэрт гардаг агуйд амьдардаг нэг нүдэт Циклоп мангасын адил хэзээ ч "нар нь жаргадагүй тэнгэрийн хаяа"-г ширтдэг болсон" (2005:18) гэж хэлсэн байдаг. Үүнтэй санал зөрөх хүн ховор биз ээ.

Орон зайн онолыг баримталдаг эрдэмтдийн хувьд энэ бол яах аргагүй том өөрчлөлт мөн юм. Гэтэл Уэбстер мэдээллийн буюу сүлжээний нийгэм яг хэзээ бодит зүйл болох вэ? Бид шинэ нийгэм рүү ямар шалгуураар орох вэ? Сүлжээ хэзээ жинхэнэ утгаараа сүлжээний үүргийг гүйцэтгэх вэ? гэж асуусан байна. Энэ бол барим тавим хариулах боломжгүй түвэгтэй асуудал юм. Хоёр хүн хоорондоо Интернетээр, эсвэл гар утсаар холбогдонгуут сүлжээ болох уу? Эсвэл тухайн албан газар Интернетэд холбогдсоноор уу? Эсвэл гэрийн компьютерүүд банк, дэлгүүр мэтийн газартай холбогдохоор сүлжээ үүсэх үү?

Түүнчлэн Уэбстер энд мэдээллийн ямар шинжийг баримтлан сүлжээний нийгмийг тодорхойлоод байгаа нь ойлгомжгүй юм гэж үзсэн байна. Энд бид сүлжээг Wi-Fi, broadband зэрэг технологийн систем талаас нь тодорхойлоод байна уу, эсвэл мэдээллийн урсгалын хэмжээгээр тодорхойлоод байна уу? гэсэн асуудал зүй ёсоор гарч ирнэ. Хэрэв технологийн систем талаас нь юм бол

ISDN мэтийн дэвшилтэт систем байж болно. Гэхдээ яаж, ямар аргаар тодорхойлох вэ? Хэрэв нэгж хугацаанд урсан өнгөрөх мэдээллийн хэмжээгээр бид сүлжээний буюу мэдээллийн нийгмийг тодорхойлоод байвал ямар хэмжээтэй, хурдтай мэдээлэл нь шинэ нийгэм ирсэн гэдгийг батлах вэ? гэсэн асуулт ар араасаа шил даран гарч ирэх нь тодорхой юм. Уэбстерийн тавьсан өөр нэг асуулт бол сүлжээний нийгмийн тухай яагаад заавал одоо ярьж эхэлж байгаа юм бэ? Урьд нь огт байгаагүй юм уу? Орчин үеийн нийгэмд хөгжсөн шуудангийн харилцаа холбоо сүлжээ биш гэж үү? Бүр түүнээс өмнө байсан буухиа шууданг юу гэж үзэх вэ? гэсэн асуултуудыг тавьсан байдаг. Тэрбээр иймэрхүү мэдээллийн сүлжээгүйгээр ямар ч улсын эдийн засаг, нийгэм, улс төр тогтохгүй байх байсан гэж дүгнэжээ.

Соёл. Мэдээллийн нийгмийг тодорхойлдог өөр нэг сонирхолтой онол бол соёлын онолууд юм. Соёлын талаас мэдээллийн нийгмийг тодорхойлох болсон гол шалтгаан нь өнөөгийн нийгэм ба олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийгэм (media society) гэсэн хоёр ойлголтын утга нь давхацсанаас үүссэн байдаг. Гэхдээ соёлын онолын хамрах хүрээ хамаагүй өргөн юм. Тухайлбал, орчин үед газар сайгүй телевиз, сэтгүүл, сонин, зурагт хуудас, реклам, хямдхан ном товхимол, дүрс болон дуу бичлэг, кино, Интернет гэх зэрэг олон нийтийн мэдээллийн харилцааны хэрэгслийн төрлүүдийг харж болно. Энэ бол урьд өмнө байгаагүй асар их хэмжээний мэдээлэл нийгэмд эргэлддэг болсонтой холбоотой юм. Харин энэхүү мэдээлэл нь радио, телевизээр зүгээр нэг цацагдаад өнгөрөхгүй, бидний өдөр тутмын амьдралыг үнэмлэхүй утгаараа тодорхойлж бай-

даг юм. Үүний учир нь бидний хувцаслаж байгаа байдал, хувцасны хэв загвар, үсээ, нүүрээ янзалсан байдал, үг яриа, өдөр тутмын амьдралын хэмнэл болгосон "Gangnam style" мэтийн дуунууд амьдралыг өмнөх цаг үеэсээ илүү мэдээллийн агууламжтай болгосонд оршиж байна. Үнэн хэрэг дээрээ энэхүү тоолж баршгүй ОНМХ биднийг янз бүрийн, хэмжээ хязгааргүй мэдээллээр бөмбөгдсөөр байна. Энэ мэдээлэл дотор хэрэгтэйгээс нь хэрэггүй, ашиггүй нь хамаагүй их юм.

Нийгмийн соёлын энэхүү "тэсрэлт"-ийг анх Австрийн социологичид болох Макс Хоркхаймер, Теодор Адорно (2002) нар нэлээд шүүмжлэлтэйгээр авч үзсэн байдаг. Тэд бидний одоо үед амьдарч байгаа нийгэм нь аж үйлдвэрийн үеийнх шиг хүнд механизм бүхий машинт үйлдвэрлэл биш, харин соёлын үйлдвэрлэлээр (culture industry) тодорхойлогддог болсон гэж үзжээ. Өнөө үеийн элдэв янзын кинонууд, хөгжим, клипүүд бүгд үнэн хэрэгтээ ашгийн төлөө бүтээгдэж байгаа зүйл бөгөөд аль хэдийнэ урлаг гэдэг утгаа алдсан гэж үзсэн нь чухал дүгнэлт юм. Орчин үеийн нийгэмд соёл, бизнес хоёрын хооронд ялгаа байхгүй болсон бөгөөд аливаа соёлын бүтээгдэхүүний амжилтыг мөнгөөр хэмждэг болсон. Жишээлбэл, дэлхийд тэргүүлдэг кинонуудын амжилтыг урлагийн үнэлэмжээр биш, box office-ийн орлогоор тодорхойлдог.

Өнгөцхөн харахад энэхүү соёлын үйлдвэрлэлүүд биднийг тэжээгээд байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлдэг нь тэдний үзэл суртлын халхавч, үр дагавар юм. Үнэн хэрэг дээрээ эдгээр үйлдвэрлэлүүд нь бидэнд хэрэгтэй, хэрэггүй хэрэгцээ гэдэг зүйлийг бий болгож, эдийн засаг болон сэтгэл зүйн хувьд мөлжиж байдаг.

Маркс тухайн үед ажилчдыг капиталистууд нэмүү өртөг бүтээлгэх замаар үйлдвэрлэлийн аргаар мөлждөг гэж үзсэн бол соёлын үйлдвэрлэл хөгжсөн өнөө үед бид бараг 24 цагийн турш мөлжүүлэхэд бэлэн байдаг. Тухайлбал, ажлаасаа ядарч ирсэн хүн гэрээ амрах орон зай гэж боддог бол одоо үед энэ нь алдагдсан гэж хэлж болно, учир нь өнөө зурагт мэтийн ОНМХ биднийг сатааруулан "ховсдох" болсон. Социологичид Хоркхаймер, Адорно нар кино, драм мэтийн зүйлүүд уг нь маш энгийн масст зориулсан зүйл болохынх нь хувьд бидний толгойд зүгээр сатаарсан байхад хүртэл орж ирж сэтгэлгээг хүртэл энгийнжүүлж байна хэмээн үзсэнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Судлаачид соёлын үйлдвэрлэлийн өдөр тутмын амьдралд илэрдэг хэлбэр нь биднийг байнга дагаж байдаг реклам сурталчилгаа гэж үзсэн байдаг. Зар сурталчилгаа бол өнөөдөр бидний маргааш юу сонгохыг тодорхойлж байдаг соёлын үйлдвэрлэлийн заль мэх юм. Тиймээс Адорно "Зар сурталчилгаа бол яг л арьсны зүү шиг бидний толгойд мэдээлэл "тарьж" байдаг зүйл" гэж хэлсэн юм. Бидний хэрэгцээнээс авахуулаад, бид ямар байх ёстойг хүртэл заадаг зар сурталчилгаа гэдэг зүйлийн хэр хол явах нь тодорхойгүй зүйл. Үүнтэй холбоотой маш энгийн жишээ татахад нөхөр нь ажлаасаа гэртээ ирэн эхнэрийнхээ хийсэн хоолыг амтархан идэж буйг харуулсан сурталчилгаа нь угтаа эмэгтэй хүний аз жаргал гал тогоонд, эр хүний явдал гадаа гэдэг энгийн жендерийг нийгэмшүүлж байгаа хэрэг юм. Зар сурталчилгаа болгон таны аз жаргалыг нэмэгдүүлнэ хэмээн амалдаг билээ. Энэ бол XX дунд үеэс тодорхой болсон бидний өнөөгийн

нийгмийн дүр төрх юм гэж дээрх эрдэмтэд үзжээ. Харин Францын социологич Жан Будриар (1983) мэдээллийн тэсрэлт нь үнэн хэрэгтээ бидний нийгмийг утгагүй болгож байна гэж үзсэн нь анхаарал татах дүгнэлт мөн. Тэрээр мэдээлэл гэсэн үгнээс илүү тэмдэгт (sign) гэсэн үгийг ашигласан бөгөөд өнөө үед нэг хүн ердөө ганцхан цаг телевизийн өмнө суугаад дундад зуунд нэг хүн бүхэл бүтэн амьдралынхаа туршид олж авч чадахгүй тийм их тэмдэгтийг "хэрэглэж" байна гэж үзсэн байна. Хоркхаймер, Адорно нарын хэлсэнчлэн бидний эргэн тойрон дүүрэн тэмдэгт ба биднийг тасралтгүй бөмбөгдөж буй тэр олон зүйлээс аль нь чухал, аль нь чухал биш вэ гэдгийг мэдэх боломжгүй юм. Бидний нийгэм утгагүй болж эхэлж байна гэж тэд хэлсний утга учир нь чухам үүнд оршино. Энэ бол мэдээлэл их байх тусам, тэр хэмжээгээр утгаа алдана гэсэн үг юм. Тухайлбал, дундад зуунд хувцас хүний статусыг заадаг байсан бол одоо энэ зарчим аль хэдийнэ алдагджээ.

Орчин үед бидний эргэн тойрноос ирж байгаа энэ их тэмдэгт ямар нэгэн бодит байдлыг төлөөлдөг гэсэн чанараа алдсан ба үүнийг хүмүүс сайн мэднэ. Ар араасаа цуварч буй тэмдэгтүүд ямар бодит байдлыг илэрхийлж байгаа нь тодорхой бус бөгөөд Будриарын хэлсэнчлэн өөрсдөө бодит байдал дээр "хөвдөг бодит байдал" буюу hyper-reality юм. Телевизээр гарч байгаа мэдээ бол бодит байдлыг харуулж байгаа хэрэг биш, харин телевизийн студид найруулан эвлүүлсэн бодит байдлын симуляци (simulation) буюу дууриамал бодит байдал юм.

Судлаачийн үзсэнээр нэгэнт утгагүй болсон тэмдэгтүүд буюу мэдээллээр

дүүрсэн нийгэмд хүмүүс тэдгээрийг зүгээр л сонгодог болсон бөгөөд хоолны жорыг өөрөө зохиохтой адил өөрийн хүссэн хэмжээгээрээ тэдгээр тэмдэгтүүдийг нэмж хасан бүтээдэг болсон байна. Нийгэмд янз бүрийн утга агуулга бүхий тэмдэгтүүд эргэлдэж байдаг мэт боловч үнэн хэрэгтээ тэд утгагүй байдаг ажээ.

Судлаач Уэбстер "энэхүү мэдээллийн нийгмийн загварыг бид ихэнх тохиолдолд амархан хүлээж авдаг боловч "шинэ" нийгэм болохынхоо хувьд өмнөх сэдвүүдээс бүрхэг юм" гэж үзжээ. Учир нь мэдээллийн нийгмийн соёлын онолыг баримтлагчид "энэ чинь ойлгомжтой шүү дээ, бид үнэхээр тэмдэгтээр дүүрсэн нийгэмд амьдарч байна" гэж хариулдаг байна. Тэгтэл Уэбстер бодит байдал дээр үнэхээр (өмнөх үеэсээ) их тэмдэгт байгааг яаж мэдэж байна? Хэрхэн ямар шалгуураар өнөөгийн нийгмийг бид 1920, магадгүй 1950 оны нийгмүүдээс ялгаатай гэдгийг мэдэх вэ? гэсэн асуултуудыг тавьсан байна.

Зургаа дахь хувилбар? Мэдээллийн нийгмийн онолчдоос Уэбстерийн олж харсан хамгийн чухал зүйл нь мэдээллийн нийгмийг тодорхойлоод байгаа судлаачдын шалгуурууд нь маш бүдэг, тодорхой бус байна гэсэнд оршино. Хүмүүс "мэдээллийн нийгэм" гэж ярих дуртай боловч чухам юуг үндэслээд ингэж хэлээд байгаа нь тодорхойгүй гэдэг нь үнэн юм. Гол үндэслэл болгож буй зүйл нь өнөө үеийн нийгэмд асар их мэдээлэл эргэлдэж байна гэсэн үзүүлэлт юм. Тэгвэл их мэдээлэлтэй байгаа нь мэдээллийн нийгэм ирсэн гэсэн үг мөн үү? Аливаа шинэ нийгэм ирсэн гэж үзвэл тэр нь ямар нэгэн тоон үзүүлэлтээр (quantitative) бус, харин чанарын (qualitative) өөрчлөлтөөр

тодорхойлогдох ёстой гэсэн үг юм. чанарын өөрчлөлтөөр тодорхойлогдоно гэдгийг Уэбстер нарийн тодорхойлоогүй ч, аливаа юмны тоо ихсэх буюу багасах нь шинэ нийгэм рүү орж байна гэсэн үг биш гэж үзсэн байна. Тухайлбал, Уэбстерийн үзсэнээр орчин үед дэлхий дээр өнгөрсөн зууны дунд үеийг бодвол хамаагүй их автомашин байгаа нь XXI зууны эхэн үеийг "автомашинь зуун" болгоогүй, мөн одоо хоол хүнсний төрөл өмнөх үеэсээ хамаагүй их байгаа нь хэнийг ч "манай зуун хоолны зуун мөн" гэж хэлэхэд хүргээгүй байна. Хэрэв ийм маягаар яваад байвал зуун болгон өөрийн "онцлогтой шинэ зуун" болох ёстой юм.

Ингэж хэлэх болсон шалтгаан нь бас өгүүллийн эхэнд дурдсан орчин үеийн ба орчин үеийн дараах үеийн хөдөлгөөнтэй шууд холбоотой юм. Орчин үеийн дараах хөдөлгөөний онолчид бидний амьдарч байгаа одоогийн нийгэм бол чанарын хувьд өмнөх нийгмээсээ өөр гэж хэлдэг ба үүндээ тохируулан янз бүрийн шалгууруудыг гаргаж тавьдаг. Харин орчин үеийн хөдөлгөөний онолыг баримтлагчид бидний амьдарч байгаа одоогийн зуун бол өмнөх зууны хөгжлийн үргэлжлэл, тиймээс түүнийг "дараагийн" гэж нэрлээд байх шалтгаан байхгүй гэж үздэг. Эдгээр хоёр хөдөлгөөнийг баримтлагчдын төлөөлөгчид болох Францын философич Жан-Франсуа Лиотард (1979) орчин үеийн дараах үеийг ертөнцийг үзэх "үлэмж үзэл баримтлал" (grand narrative) бутран үгүй болсон үе гэж тодорхойлжээ. Энэ нь орчин үеийн онолууд ертөнцийг үзэх тухай үнэхээр үлэмж үзэл баримтлалыг дэвшүүлдэг байсантай холбоотой юм. Орчин үед хамаарагдах шинжлэх ухааны онолууд бүгд хэт оптимист, шинжлэх ухаанд хэт итгэдэг, аливаа

үзэгдлийг бүхэлд нь танин мэдэж хууль, зүй тогтлыг нь бүрэн илрүүлнэ гэж үздэг байсан. Тэдний ярьдаг гол сэдвүүд бол түүх, нийгмийн хөгжлийн хууль, чөлөөт ардчилсан нийгэм, эсвэл коммунизм гэх мэт ойлголтууд байв. Харин Лиотард орчин үед эдгээр үлэмж үзэл баримтлалууд нь хэний ч анхаарлыг татахаа больсон, утопи, боломжгүй зүйл гэж үзсэн байна. Тэрбээр хэрэв хэн нэгэн одоо хүртэл иймэрхүү зүйлд итгэдэг бол тэр орчин үеийн дараах хүн биш юм. Орчин үеийн дараах нийгэмд дээрх үлэмж үзэл баримтлалууд "бичил үзэл баримтлалууд"-аар солигдсон гэж үзжээ. Тухайлбал, шинжлэх ухааны жишээн дээр авч үзвэл одоо үеийн шинжлэх ухаан хаана ч байдаг универсаль зүй тогтол, хууль олно гэдгээ орхисон. Бүр Баруун Европын нөлөө бүхий сургуулиудад хүртэл ийм юм байхгүй, харин зөвхөн тухайн тодорхой түвшинд үйлчлээд өнгөрдөг зүй тогтлууд л олдож болно гэж заадаг.

Бидний одоогийн нийгэм хоорондоо эрс ялгаатай утга санаатай, үнэт зүйлтэй, түүнийг хэнд ч тулган хүлээлгэхгүй, тэр нь орчин үеийн дараах нийгмийн ёс зүй болсон байдаг. Харин хэн нэгэн нэг улс, нэг үндэстэнтэй байхыг эрмэлзэж, бусдыг хүлээн зөвшөөрч чадахгүй бол тэр хүн орчин үеийн дараах нийгэм рүү орох бус, харин орчин үеийн нийгмийн авчирсан сөрөг үр дагавар болох нацизм, фашизм, национализмаас ангижирч чадаагүй хүн юм. Дэлхийн II дайны үеэр болсон Holocaust буюу еврей үндэстэнг хоморголон устгах үйл ажиллагаа нь уламжлалт нийгэмд бус, харин орчин үеийн нийгэмд болсон гэдгийг санахад илүүдэхгүй юм. Түүнээс гадна орчин үеийн дараах нийгмийн хөгжил нь глобальчлагдах

үйл явцын үндсэн нөхцөл гэдгийг харгалзан үзэх шаардлагатай. Учир нь глобализм гэдэг нь олон соёл, олон үндэстнийг хүлээн зөвшөөрөх (multiculturalism) үзэгдэл мөн бөгөөд энэ нь орчин үеийн дэлхийн хөгжлийн гол чиг хандлага юм. Харин үүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй бол бүх талаараа дэлхийн хөгжлөөс шахагдан өөрөөсөө өөр хэнийг ч олж харж чаддаггүй "биеэ тоосон" нэгэн болон хувирах болно.

Орчин үеийн хөдөлгөөний онолыг баримтлагч нар өнөөгийн нийгэм бол орчин үеийн нийгмийн үргэлжлэл мөн гэж үздэгийг дээр дурдсан. Тэдний нэг болох Английн социологич Антони Гидденс (1990; 1991) өнөө үеийн нийгмийг Дээд орчин үе (High Modernity) гэж нэрлэсэн байдаг. Тэрбээр бидний амьдарч байгаа үе бол өмнө нь байсан орчин үеийн нийгмийн хөгжлийн үргэлжлэл бөгөөд бид нар өмнөх үеийн ололтуудад тулгуурлан амьдарч байна гэж үзээд, энэ нь түүхийн цоо шинэ үе биш, харин түүний үргэлжлэл мөн гэж тэмдэглэсэн байна. Гидденс "мэдээллийн нийгэм" гэсэн үгийг ашиглаагүй ч мэдээллийн нийгэм гэж нэрлээд байгаа зүйл нь ч өмнөх үеийн үргэлжлэл мөн гэж дүгнэжээ. Харин Гидденсийн авч үзсэн хамгийн чухал санаа нь бол одоо үеийн нийгмийг мэдээллийн бус, харин мэдээлэлжиж буй (informatized) нийгэм гэж үзсэн явдал юм. Энэ бол бидний өдөр тутмын харилцаа улам бүр мэдээллийн хэлбэрт орж байна гэсэн үг юм. Орчин үеийн нийгэм үүссэнээр статистикийн салбар маш эрчимтэй хөгжсөн бөгөөд статистикийн бүртгэлд орно гэдэг нь хүн мэдээллийн хэлбэрээр орших болсон гэсэн үг юм. Харин өнөө үеийн компьютерийн шинжлэх ухааны үр дүнд мэдээллийн хэлбэрт орох нь бүр дижитал хэлбэрт шилжиж, дижитал иргэн гэсэн нэр томьёо бий

болжээ. Хурууны хээгээр цахим иргэний бүртгэлд орно гэдэг нь та улам бүр нийгэмд мэдээллийн хэлбэрээр оршиж эхэлж байна гэсэн үг юм. Энэ бол орчин үеийн онолын хөдөлгөөнийг баримтлагчдын хардаг гол өнцгийн нэг мөн.

Гэхдээ Гидденс үнэхээр өнөө үе мэдээллийн нийгэм юм бол энэ нь тухайн нийгмийн зохион байгуулалттай шууд холбоотой гэж үзсэн байдаг. Учир нь үеийн үед аливаа нийгмийг зохион байгуулахад хяналт (surveillance) болон мэдээлэл (information) ямагт хэрэгтэй байсан ажээ. Оновчтой зохион байгуулахын тулд аливаа этгээд тухайн зохион байгуулалтын тухай ямагт мэдээлэл хүртэж байх ёстой бөгөөд үүнийг аль болох хамгийн төгс хяналтаар хэрэгжүүлдэг. Тиймээс орчин үеийн нийгмийг хүн бүрийг цахим үнэмлэхтэй болгох зэргээр мэдээлэлжүүлж байгаа нь иргэн бүрийг хянах тохиромжтой арга юм. Мөн зээлийн карт, гар утас гэх мэт зүйл ч дээрх үүргийг шууд гүйцэтгэдэг.

Хэрэв дээрх хоёр жишээг харьцуулж үзвэл нэг нь зөв, нөгөө нь буруу гэж хэлэхэд тун түвэгтэй юм. Учир нь аль аль нь үнэний хувьтай, аль аль нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлалууд юм. Харин аливаа зүйлийг яаж тодорхойлж байна вэ гэдэг нь тухайн эрдэмтний харах өнцөг бөгөөд асуудлын гол нь ямар нэгэн зүйлийг баримтлан дэвшүүлж буй онолоо логикийн хувьд алдаагүй зөв томьёолж чадахад оршино.

Уэбстер мэдээллийн нийгмийн шүүмжлэгч болохын хувьд өнөө үеийн нийгмийн мэдээлэлжиж байгаа үзэгдэл нь капиталист нийгмийн хөгжлийн үр дүн гэж үзсэн байна. Тэрээр Гидденсийн нэгэн адил өнөө үеийн нийгэм түүхийн үргэлжлэл болохоос өөрчлөлт

биш гэж дүгнэжээ. Капиталист нийгэм ашиг хардаг рациональ нийгэм болохынхоо хувьд хамгийн рациональ аргыг сонгох нь өөрөө мэдээлэлжүүлэх үйл явц юм. Гэхдээ мэдээлэлжүүлэх нь шинэ зүйл биш, хэдэн зууны турш үргэлжлэн явагдаж, капитализмын үед улам эрчимтэй явагдсан үзэгдэл мөн. Энэ үйл явц нь орчин үед глобализм болон үндэстэн дамнасан корпорациудын хөгжлийн үед улам эрчимтэй явагдаж, урьд хожид байгаагүй орон зайг хамрах болсон юм.

Уэбстер мэдээллийн нийгэм байгаа юу, эсвэл ийм зүйл байх боломжтой юу? гэсэн асуултад шууд хариулаагүй орхижээ. Тэрээр мэдээллийн нийгмийн онолчдын хэрэглэж буй ойлголт нь тун бүдэг бөгөөд хүн болгон мэдээллийн нийгмийн тухай ярьдаг боловч нэг ч хүн мэдээллийн нийгэм гэж ямар нийгэм болох тухай, бүр мэдээлэл гэж юугаа яриад байгааг тодорхойлоогүй байдаг хэмээн үзжээ. Тэрээр эдгээр онолчид "мэдээлэл" гэдгийг харилцаа холбооны шинжлэх ухаанд хэрэглэдэг ойлголтоос шууд буулгаж авсан нь буруу гэж үзсэн байна. Тодруулбал, 1948 онд Америкийн судлаачид Клод Шэннон, Уоррен Уивер (1964) нар орчин үеийн инженер, математикийн салбарт хэрэглэгддэг мэдээллийн онолоо боловсруулж, энэхүү мэдээллээ хэмжигдэхүүн болгон авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тэд мэдээллийг бидний сайн мэддэг бит хэмжигдэхүүн рүү оруулан зөөвөрлөж болдгийг нээсэн юм. Хэлбэрт оруулан зөөвөрлөж болно гэдэг нь мэдээлэл зөвхөн тоон хэмжигдэхүүний хэлбэрээр оршдог гэсэн үг юм. Харин Уэбстер энэхүү математикийн ойлголтыг нийгмийн шинжлэх ухаанд шууд хэрэглэхэд хамаг асуудал оршиж байна гэж үзсэн байна. Тэрбээр мэдээллийг зөвхөн хэлбэр талаас нь авч үзэх нь наад заах

нь энгийн ярианы ойлголтын шалгуурыг хангахгүй бөгөөд бид ямагт юуны тухай мэдээлэл вэ гэдгийг анхаарч байдаг гэж үзсэн нь сонирхол татах асуудал мөн. Мэдээлэл юуны түрүүнд хэлбэрээр бус, харин чанарын ялгаагаар (юу? хэнд зориулж?) тодорхойлогдож байдаг онцлогтой. Тиймээс мэдээллийн агуулгыг (content) алдагдуулан хэлбэрээр (form) нь тодорхойлох нь бодит байдалд нийцэхгүй. Бидний дээр дурдсан бараг бүх эрдэмтэн ингэж үзсэн нь маргаан дэгдээх гол үндэслэл болж байна.

Эрдэмтэн Уэбстер энэ бүхэнд нарийн дүн шинжилгээ хийсний эцэст мэдээллийн нийгмийн онолоо гаргаж тавьсан байна. Түүний энэ онол нь тун энгийн юм. Тэрээр хэрэв мэдлэг болон мэдээлэл хоорондоо ялгаагүй бол өнөөгийн нийгмийг өмнөх нийгмүүдээс ялгаж өгдөг хамгийн гол ялгаа нь орчин үед урьд өмнө байгаагүй онолын мэдлэг (theoretical knowledge) ихэссэн явдал гэж үзжээ. Яагаад онолын мэдлэг тийм чухал болов? Анх XVIII зуунд орчин үеийн бүгд найрамдах улс байгуулагдан "төрийн бүх эрх ард түмэнд байна" гэж тунхаглаж, иргэн (citizen) гэдэг ойлголт гарч ирэхэд энэхүү онолын мэдлэг онцгой чухал байжээ. Учир нь нэгэнт төрийн эрх мэдэл ард түмний гарт очиж, ард түмэн төрийг болон өөрсдийгөө удирдах ёстой юм бол ард түмэнд энэхүү чадварыг нь өгөх ёстой гэсэн үндэслэлээр анхны боловсролын тогтолцоо байгуулагдсан түүхтэй. Энэ үед онолын мэдлэгийн мөн чанар, хэрэгцээ тодорхой болж, иргэд төрөөр дамжуулан өөрсдийгөө яаж удирдахыг заасан рациональ мэдлэг байх ёстой гэж үзжээ (Wallerstein, 2004). Ийм мэдлэг нь практикийг аргалчих төдий мэдлэг биш, харин хаана ч хэрэгжих

магадлалтай ерөнхий, хийсвэр, ойлгомжтой мэдлэг байх ёстой байв. Үүнийг онолын мэдлэг гэж тодорхойлсон байна. Энэ утгаараа боловсролын тогтолцоо ардчиллыг хэрэгжүүлэх гол механизм болжээ (Gramsci, [1971] 1992). Ийм маягаар анхны нийгмийн шинжлэх ухаанууд үүсч эхэлсэн түүхтэй юм. Аажим аажмаар энэхүү онолын мэдлэг нь нийгмийн бус бусад салбар руу тархан хүн болгонд өгөөжөө өгч эхэлжээ. Орчин үед хүмүүс хэрэгцээтэй онолын мэдлэгүүдийг хаанаас ч олж авах боломжтой бөгөөд эдгээр мэдлэг нь ном, сонин, сурах бичиг, Интернет, сургууль зэрэг янз бүрийн хэрэгслийн хэлбэрээр оршиж байна. Мөн тэдгээрийн тоо, хэмжээ ч байнга өсөн нэмэгдсээр байна.

Тиймээс Уэбстер энэхүү онолын мэдлэгүүд өнөө үеийн нийгмийг тодорхойлж байгаа тул түүнийг мэдээллийн биш мэдлэгийн нийгэм гэж тодорхойлох шаардлагатай гэж дүгнэжээ.

Тэгвэл орчин үеийн Монголын нийгэм мэдээллийн нийгэм мөн үү? гэсэн асуулт тавигдаж болох юм. Хэрэв Уэбстерийн онолоор авч үзвэл Монголын нийгэм мэдээллийн нийгмээс дэндүү хол байна гэж хэлэх үндэстэй. Учир нь манай улсад байгаа мэдлэг буюу мэдээлэл үйлдвэрлэж байдаг институтууд (сургууль, номын сан, номын дэлгүүр, ОНМХ г.м.) хэр их байна вэ? Байгаа нь хэр зэрэг

чанартай байна вэ? гэдэг асуултууд гарч ирнэ. Чанартай, чанаргүй хэдэн сургууль, тэдний материаллаг бааз, зааж буй хичээлүүд нь Монгол Улсыг дэлхийн түвшинд аваачина гэвэл дэндүү өрөөсгөл дүгнэлт болно. Хэрэв судлаачдын хэлсэнчлэн боловсролын тогтолцоо үнэхээр ардчиллыг хэрэгжүүлэх гол механизмын нэг мөн юм бол өнөөгийн Монгол Улсад боловсрол тийм үүргийг гүйцэтгэх түвшинд хүрэх нь байтугай ойртоо ч үгүй юм. Манай орны өнөөдрийн боловсролын тогтолцоо бидэнд Австрийн эдийн засагч Хайекийн хэлсэн "Улс төрчдийг солих гэж оролдсоноос, тэднийг сонгож байгаа хүмүүсийг солих" гэсэн үгийг санагдуулж байна.

«

Монголын боловсролын тогтолцоо шинэчлэгдэхгүй байгаа нь олон шалтгаантай холбоотой. Хамгийн гол нь боловсролыг зоригтой шинэчлэх нь Монголын төрийг барьж буй эрх мэдэлтнүүдэд ашиггүй юм. Мэдээж тэдэнд одоогийн УИХ-ын гишүүн С.Ганбаатар шиг мэдлэг боловсролтой хүмүүс ихсэх нь ашиггүй. Эрх баригчид нийгмийг ийнхүү дорой байлган өөрсдийн тоглолтоо хийн ард түмнийг мөлжих нь тэдэнд ямагт ашигтай.

»

Монголын боловсролын тогтолцоо шинэчлэгдэхгүй байгаа нь олон шалтгаантай холбоотой. Хамгийн гол нь боловсролыг зоригтой шинэчлэх нь Монголын төрийг барьж буй эрх мэдэлтнүүдэд ашиггүй юм. Мэдээж тэдэнд одоогийн УИХ-ын гишүүн С.Ганбаатар шиг мэдлэг боловсролтой хүмүүс ихсэх нь ашиггүй. Эрх баригчид нийгмийг ийнхүү дорой байлган өөрсдийн тоглолтоо хийн ард түмнийг мөлжих нь тэдэнд ямагт ашигтай юм. Тэгсэн мөртлөө Монголд ардчилал мандаасай гэж орилох нь бодит байдалд хэр нийцэх бол?

Өнөөдөр Монгол Улс капиталист замаар эрчимтэй хөгжиж байна гэж

хэлж болно. Харин ингэж хөгжихдөө бидний дээр дурдсан мэдээллийн нийгмийн эхний таван онолыг ямар нэг хэмжээгээр хэрэгжүүлж байгаа нь ажиглагддаг. Манай оронд харилцаа холбооны технологи эрчимтэй нэвтэрч, өөрийн гэсэн зах зээлтэй болж чадсан. Харин мэдээллийн технологийн хувьд хөгжиж байгаа боловч соёлын хувьд хэр хөгжиж байгаа нь тодорхой бус байна. Хүүхэд залуучууд "мэдээлэл хэрэгтэй", "мэдээлэл авч байна" гэж телевиз, Интернетийн ард хамаг цагаа барж байгаа нь нууц биш.

Харин тэдний авч байгаа тэр мэдээллийн ихэнх хэсэг нь үнэн хэрэг дээрээ амьдралд ямар ч ашиггүй дуу хөгжим, "савангийн дуурь" болон насанд хүрэгчдийн сайтнаас авсан "хогнууд" байдаг. Тэд капитализмын соёлын үйлдвэрлэлд оюун санаагаа мөлжүүлсээр байгаад эсэргүүцэх чадваргүй болсон гэвэл хэртүүлэг болохгүй. "Та чөлөөт цагаараа юу хийдэг вэ?" гэж асуухад "Хөгжим сонсоно, зурагт үзнэ, гадуур гарна" гэх зэргээр хариулах нь манай залуучуудын дунд дэндүү түгээмэл юм. Нэгэн сэтгэгч "Чөлөөт цаг бол хамгийн хортой цаг" гэж хэлсэн нь үүний баталгаа мэт. Зарим хүн "Чөлөөт цаг бол нийгмийн баялаг" гэж хэлэх нь бий. Гэтэл манай нийгэмд энэхүү чөлөө цагаа баялаг бүтээх хөшүүрэг болгон хувиргах соёл буюу Германы социологич Макс Веберийн ([1930] 1992) хэлсэнчлэн "зөвхөн ашиг хардаг капиталист нийгмийг хазаарлан барьж тодорхой хязгаар дотор түүнийг хөгжүүлж байдаг капитализмын оюун санаа (Spirit of Capitalism)" алга байна. Энэхүү соёл нь боловсролын тогтолцооноос эхлэх ёстой юм. Тэгвэл манайд Уэбстерийн онцлон хэлсэн тэр нийгэм эхлээгүй байна.

Бид дээр мэдээллийн нийгмийн гарах болсон шалтгааныг капитализмын хөгжлийн үр дүн гэж тодорхойлсон. Нийгмийн гарлын хувьд тийм байж болно. Тэгвэл үүнээс илүү өөр шалтгаан байж болох уу? Энэ асуудлын хүрээнд мэдээллийн нийгмийн онолыг баримтлагчид үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Нэг хэсэг нь мэдээллийн нийгэм бол хүний амьдралыг илүү хялбар болгоно гэж үздэг. Тухайлбал, Японы эрдэмтэн Масуда мэдээлэл технологийн хөгжил хүний амьдралыг улам амар хялбар болгож, эцсийн дүндээ мэдээллийн Computopia (computer + utopia) нийгэмд хүргэнэ гэж үзсэн байдаг. Харин нийгэмд байгаа сэхээтнүүд үүнд хүрэхэд хамгийн тохиромжтой замыг боловсруулан туслах ёстой гэж үзсэн байна.

Мэдээллийн нийгмийн онолын нөгөө талыг баримтлагчид мэдээллийн нийгэм бол Big Brother (Америкийн тухайн байшинд юу болж байгааг харж байдаг телевизийн реалити шоуны нэр юм) нийгэмд хүргэнэ гэж үздэг (Holub, 1992). Энэ бол мэдээллийн нийгмийн хөгжил нь бидний амьдралыг хөнгөвчлөх биш, харин улам хатуу хараа хяналтанд байлгах болно гэсэн үзэл юм. Францын түүхч Мишель Фуко (1995) орчин үеийн нийгмийг Disciplined Society буюу Сахилгажсан нийгэм гэж нэрэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, таны тухай мэдээллийг нийгэмд байнга цуглуулж байдаг бөгөөд энэ нь таны хэн болох, хаана, юу хийдгийг, ямар гээчийн этгээд болохыг нэвт мэдэж авч байгаа хэрэг юм. Таны тухай хэр ихийг мэднэ, тэр хэмжээгээрээ танд эргэж нөлөөлөх боломж ихэсдэг байна. Тухайлбал, цахим үнэмлэх, иргэний бүртгэл, хурууны хээ, зээлийн карт, гар утас, Интернет, мессенжер мэтийн зүйлс нь

хэдийгээр орчин үеийн технологийн дэвшил мэт боловч биднийг хязгааргүй хянах бололцоо олгож байгаа нь тодорхой юм. Товчоор хэлбэл, өнөө үед нууцаа хадгалах, хувийн байдлаа авч үлдэх нь маш хэцүү болсон. Энэ бол Lord of the Rings кинон дээр гардагтай адил биднийг байнга харж байдаг нүд (gaze) байна гэсэн үг.

Францын социологич Вирилио аливаа нийгмийн хөгжил хамгийн түрүүнд цэргийн салбарын шинжлэх ухааны хөгжлөөс хамаарч, түүгээр тодорхойлогддог гэж үзсэн нь анхаарал татахуйц дүгнэлт юм. Шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн ололтууд зөвхөн цэргийн салбарт хэрэглэгдэж байдаг ба мөн нийгмийн зохион байгуулалт ч адил цэргийн логикийн ухаанаар тодорхойлогдоно гэж үзжээ. Тухайлбал, одоогийн бидний мэдэх Интернетийн анхны хувилбар анх 1960-аад онд АНУ-ын Батлан хамгаалах салбарт туршилтын журмаар хэрэглэгдэж, хожим энгийн ахуйн хүрээнд шилжсэн юм. 1980 оны сүүл хүртэл ARPANET гэсэн нэрээр байж байгаад 1990 оны эхээр Internet болж дэлхий даяар тархсан байдаг. Статистикийн зарим мэдээнээс үзвэл жилд 250000 хүн шинээр Интернетийн хэрэглэгч болж байдаг ба энэ нь сүүлийн үед улам нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү дэлхийг хамарсан даяар сүлжээний төв нь дэлхийд зөвхөн АНУ-д байдаг бөгөөд тэнд бүх хэрэглэгчид автоматаар бүртгэгдэж байдаг.

Вирилиогийн үзсэнээр энэ нь АНУ-д дэлхийг хянах боломж олгож байгаагийн зэрэгцээ глобализмын нөлөөгөөр улам бүр бүх дэлхийг хамарсан тоталитар шинжтэй болж байгаагийн илрэл юм. Энэхүү систем нь үнэн хэрэгтээ АНУ-ын ашиг сонирхлыг

хамгаалах хэрэгсэл болж, түүнд мэдээллээр дамжуулан хянахаас гадна шууд хохирол учруулах боломж олгодог байна. Тухайлбал, дэлхий даяар нэг цаг Yahoo! зогсоход улс гүрэн, компани, хувь хүмүүст хэчнээн хэмжээний хохирол учирч болохыг тооцоолоход бэрх юм. Үүнийг Вирилио орчин үед мэдээллийн интерактив байдлыг ашиглан "дайсан"-даа хохирол учруулж болох атомын бөмбөгийн дараа шинээр гарч ирсэн мэдээллийн бөмбөг (information bomb) гэж тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд мэдээллийн нийгэм гэдэг ойлголт нь улс төрийн зорилготой холбоотой гарч ирсэн аль нэг этгээдийн ашиг сонирхлыг халхалсан үзэл суртал (ideology) байж болох юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Baudrillard, Jean. 1983. In the Shadow of the Silent Majorities; or, The End of the Social and Other Essays. Translated by Paul Foss, John Johnson and Paul Patton. New York: Semiotext(e).
2. Bell, Daniel. 1976. The Coming of Post-Industrial Society. New York: Basic Books.
3. Castells, Manuel. 1996-8. The Information Age: Economy, Society and Culture, 3 volumes. Oxford: Blackwell.
4. Foucault, Michel. 1995. Discipline and Punish: The Birth of Prison. Translated by Alan Sheridan. New York: Vintage Books.
5. Giddens, Anthony. 1991. Modernity and Self-Identity: Self and Society in the Late Modern Age. Cambridge: Polity.
6. Giddens, Anthony. 1990. The Consequences of Modernity. Cambridge: Polity.
7. Gramsci, Antonio. [1971] 1992. The Selections from the Prison Notebooks. Edited and translated by Quintin Hoare and Geoffrey Nowell Smith. New York: International Publishers.
8. Holub, Renate. 1992. Antonio Gramsci: Beyond Marxism and Postmodernism. London and New York: Routledge.
9. Horkheimer, Max and Theodor W. Adorno. 2002. Dialectic of Enlightenment:

Philosophical Fragments. Translated by Edmund Jephcott. California: Stanford University Press.

10. *Leadbeater, Charles*. 2000. *Living on Thin Air: New Economy*. New Ed. Canada: Penguin Books.

11. *Lyotard, Jean-Francois*. 1979. *The Postmodern Condition: A Report on Knowledge*. Translated by Geoff Bennington and Brian Massumi. Manchester: Manchester University Press, 1984.

12. *Masuda, Yoneji*. 1981. *The Information Society as Post-Industrial Society*. Washington: World Future Society.

13. *Porat, Marc Uri*. 1977. *Information Economy: Definition and Measurement*. Superintendent of Documents, U.S. Government Printing Office, Washington, D.C. 20402 (Stock No. 003-000-00512-7).

14. *Shannon, Claude and Warren Weaver*. 1964. *The Mathematical Theory of Communication*. Urbana, Ill.: University of Illinois Press.

15. *Toffler, Alvin*. 1970. *Future Shock*. New York: Bantam Books.

16. *Toffler, Alvin*. 1980. *The Third Wave*. New York: Bantam Books.

17. *Virilio, Paul*. 2005. *The Information Bomb*. Translated by Charles Turner. London and New York: Verso.

18. *Wallerstein, Immanuel*. 2004. *World-Systems Analysis. An Introduction*. Durham and London: Duke University Press.

19. *Weber, Max*. [1930] 1992. *The Protestant Ethic and the Spirit of Capitalism*. Translated by Talcott Parsons. London and New York: Routledge.

20. *Webster, Frank*. 2006. *Theories of the Information Society*. Third Edition. London and New York: Routledge.

Abstract

This article discusses the definitions of information society basing on the analysis of British sociologist Frank Webster. The article critically analyzes the concept of information society showing its vulnerability and ambiguity and discusses its broader connections with concepts such as modernity and post modernity. It questions the possibility of information society from critical standpoint and its usage of concept in academic circles. At the end, it brings rather different "alternative" of information society of Webster not common in mainstream discourse of sociology of advanced societies. The article also discusses the political, social and global dimensions of information society.